

**“САРУУЛ БАЯН УУЛ-
АУДИТ” ХХК**

СҮМБЭР СУМЫН 2 ДУГААР СУРГУУЛЬ

Аудитын тайлан

АГУУЛГА

ХУУДАС

**Нэмэлтмэдээлэл авахыг хүсвэл
доорх хаягаар харилцана уу:**

Захирал Б.Шатар
Утас: 89383852
Цахим хаяг: baldandorjshatar@yahoo.com

- Аудитын гэрчилгээ
- Менежментийн захидал
- Аудит хийсэн санхүүгийн тайлан
- Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Гэрээт аудитор Д.Оюунбат
Утас: 89585807
Цахим хаяг: oyuna200702@yahoo.com

Хаяг:
Дундговь аймаг Сайнцагаан сум 7 дугаар
баг

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	Error! Bookmark not defined.
2	Аудитын тайлан.....	2
2.1	Оршил.....	2
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	2
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	3
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	3
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	4
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	4
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	5
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	6
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал	Error! Bookmark not defined.
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал	
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал .	
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.12	Шилэн дансны мэдээлэл	8
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал	9
3.1	«management_zurchil1».....	
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	Error! Bookmark not defined.
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	Error! Bookmark not defined.
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	Error! Bookmark not defined.
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	Error! Bookmark not defined.
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	Error! Bookmark not defined.

1 Аудитын тайлан

1.1 Оршил

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын "2 дугаар сургууль"-ийн төсвийн захирагч О.Базарбаатар танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын "2 дугаар сургууль"-ийн 2017 оны санхүүгийн тайланг баталгаажуулах аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын "2 дугаар сургууль"-ийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилго юм.

Төсвийн захирагч нь санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилго юм.

Тус газар нь 2017 оны санхүүгийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 06 дугаартай албан бичгээр хуулийн хугацаанд ирүүлсэн байна.

Аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 02 дугаар сарын 25-ны хооронд хийж, аудитын тайланг эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, гэрээт аудитор Д.Оюунбат хариуцаж хэрэгжүүлэв.

1.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж–Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000-1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

1.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Говьсүмбэр аймгийн “Биеийн тамир, спортын газар” нь “Орон нутгийн хүн амд биеийн тамир, спортын боловсрол олгон бүх нийтийн хэрэглээ болгох, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, өндөр зэрэгтэй баг тамирчдыг бэлтгэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор 2017 онд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллажээ.Үүнд:

- Нийтийн биеийн тамирын арга хэмжээг тогтмол зохион байгуулах, иргэдийг өргөнөөр хамруулах.
- Өсвөрийн шигшээ багийн сургалт, дасгалжуулалтыг сайжруулах, бүс, Улс, Олон улсын тэмцээнд амжилттай оролцох.
- Оюутны спортын их наадамд амжилттай оролцох.
- Спортын салбар холбоодын хамтын ажиллагааг сайжруулах гэсэн зорилтуудыг дэвшүүлэн ажиллажээ.

Тус байгууллагын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын "2 дугаар сургууль"-ийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараахь хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- ХХОАТ-ын тухай хууль
- НД-ын тухай хууль

1.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Биеийн тамир, спортын газар нь байгууллагын даргын тушаалаар 2015 онд баталсан НБББББ-ийг мөрдөж байна. Холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтүүд хийгдсэн байна.

Говьсүмбэр аймгийн "Биеийн тамир, спортын газар"-ын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Тус газар нь санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд "Гүүк сорт" ХХК-ийн "Axplorer" программ хангамжийг 2016 оноос эхлэн ашиглаж байна.

Санхүүгийн програмд Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлж шинэчлэлт өөрчлөлтүүдийг тухай бүр хийлгэсэн байна.

1.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын "2 дугаар сургууль"-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулья.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн тодорхойлсон уламжлалт болон хяналтын эрсдэлийн дагуу горим хэрэгжүүлэн тэдгээрийг ТАБ-СТА-АБ.1-АБ.8 маягтуудаар баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 5 асуудал эрсдэл өндөр гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд зайлшгүй шалгах эрсдэлтэй 5 асуудалд аудитыг чиглүүлэн, аудитын горим

сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

1.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ийн дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь орлогын дүнд тухайн байгууллагын үйл ажилагаанд зарцуулагддаггүй орлого тооцогдох магадлалтай бөгөөд нийт хөрөнгө болон цэвэр хөрөнгийн дүн бага байгаа тул нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зүйтэй гэж үзсэнтэй холбоотой юм.

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын "2 дугаар сургууль"-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийн үеийн материаллаг байдлын түвшинг үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 431,976.2 мянган төгрөгөөс 1% буюу 4,319.8 мянган төгрөгөөр тооцсон бөгөөд гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлын түвшинд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэж /ТАБ-СТА-В-1/ маягтаар баталгаажууллаа.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 1%-иар тооцсон нь сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлангийн аудитаар "зөрчилгүй", 2016 онд Монгол Улсын Ерөнхий аудитораас итгэл үзүүлж "Зөрчилгүй" дүгнэлт өгсөнтэй холбоотой юм.

Гүйцэтгэлийн явцад шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илрээгүй.

1.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын төлөвлөлтөөр нийт 8 дансанд эрсдэлтэй гэж тооцож, горим, сорил хэрэгжүүлэх явцад 5 дансанд алдаа зөрчил илрээгүй тул нарийвчилсан горим сорил хийгдээгүй бөгөөд зөрчилтэй гэж үзсэн 3 дансанд нарийвчилсэн горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баталгаажуулав. /ТАБ-СТА-В.3.1-В.3.3/, /ТАБ-СТА-В.3.9/

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дахь залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараахь байдлаар ангилав.

(мянган төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	2	0	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Аудитын явцад залруулсан	3	10,187.6	
5	Залруулагдаагүй алдаа	0	0	
6	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
7	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	5	10,187.6	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг /ТАБ-СТА-В-4.3-4.4/ маягтад нэгтгэн баримтжуулав.

1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Тус байгууллага нь өөрийн орлогыг арилжааны банкаар дамжуулан тушаахдаа үйлчилгээний шимтгэлд төлсөн 100.5 мянган төгрөгөөр Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн орлого, зардлыг бууруулж тайлагнажээ.
Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 6 дугаар зүйлийн 6.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулах

2. Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа 3,200.0 мянган төгрөгийн сагс, волейволын бөмбөгийг шууд зардлаар, үндсэн хөрөнгийн элэгдлийг 6,887.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнажээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулах

3. Байгууллага, иргэнтэй байгуулсан гэрээнүүд нь нэгдсэн журмаар дугаарлагдаагүйгээс хянах боломжгүй бөгөөд гэрээг дүгнэж, акт үйлдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

4. Биеийн тамир спортын зааланд явагдаж буй уралдаан тэмцээнээс зөвхөн УАШТ-ийг үзэгчдэд билет тасалж орлого бүрдүүлсэн байна. Харин жилдээ бүсийн тэмцээн уралдаан 2-3 удаа явагддаг боловч үнэгүй төлбөргүй явуулж орлого олох боломжийг алдсан, орлого бүрдүүлэх талаар идэвх санаачлагатай ажиллаагүйгээс тайлант жилийн орлогын төлөвлөгөө 282.7 мянган төгрөг буюу 1.3 хувиар тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, 6.4.1, 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

1.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

Акт байхгүй

1.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

Албан шаардлага байхгүй.

1.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар алдаа зөрчилтэй асуудал гараагүй.

1.9.4 Хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр алдаа зөрчилтэй асуудал гараагүй.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын "2 дугаар сургууль"-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 10,187.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 100 хувь залруулж, 2 зөвлөмж өглөө.

1.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татсан асуудал байхгүй байна.

1.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын "2 дугаар сургууль"-ийн өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой хөтөлбөр, арга хэмжээн урсгал зардалд зориулан 165,055.8 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

		/мянган төгрөгөөр/			
№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	293,968.3	291,723.5	-0.7%	-2,244.8
1.1	Урсгал зардал	293,968.3	291,723.5	-0.7%	-2,244.8
1.2	Хөрөнгийн зардал	0	0	0.0%	0.0
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	0	0	0.0%	0.0
2	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	293,968.3	291,723.5	-0.7%	-2,244.8
2.1	Улсын төсвөөс санхүүжих	271,968.3	270,006.2	-0.6%	-1,962.1
2.2	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих				
2.3	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	22,000.0	21,717.3	-1.3%	-282.7

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын "2 дугаар сургууль" нь 2017 онд 293,968.3 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдсан бөгөөд төсвөө 100% авч, үйл ажиллагааны зардалд 291,723.5 мянган төгрөгийг зарцуулж, төсвийн хэмнэлт 1,962.1 мянган төгрөг буцаан төвлөрүүлж, өөрийн орлогын төлөвлөгөө тасарсан 282.7 мянган төгрөгийн хэмжээгээр төсөв дутуу зарцуулагдсан байна. Төсвийн хэмнэлт 1,962.1 мянган төгрөг нь цалин, тогтмол зардлууд хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсвийг нийт дүнгээр хэтрүүлээгүй бөгөөд аймгийн төрийн санд хүсэлт гаргаж, тогтмол зардлын хэмнэлтээс 2,417.7 мянган төгрөгийг цалин хөлсний зардалд бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна.

Тус газар нь оны эхэнд 39.3 мянган төгрөгийн авлагатай, өглөггүй байсан ба тайлант хугацаанд 39.3 мянган төгрөгийн авлага барагдаж, өглөг, авлагын эцсийн үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны 2017 оны эхний үлдэгдэл 43,994.7 мянган төгрөг байсан бөгөөд тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 14,742.4 мянга, үндсэн хөрөнгийн данснаас шилжүүлэн авсан 1,661.6 мянга, нийт 16,403.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант жилд зарцуулсан 12,512.4 мянга, Орон нутгийн өмчийн газрын 2017 оны 181 тоот албан бичгийг үндэслэн байгууллагын даргын 2017 оны А/18 дугаар тушаалаар аймгийн ЗДТГ-т шилжүүлсэн 2,005.0 мянга, акталсан 1,577.2 мянга, нийт 16,094.6 мянган төгрөгөөр хасагдаж, 44,304.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ.

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,799,412.2 мянган төгрөг байсан бөгөөд тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 2,695.0 мянган төгрөгийн хөрөнгө авч, аймгийн ИТХТ-ийн 2017 оны 53-р тогтоолын дагуу 11 нэр төрлийн 8,279.7 мянган төгрөгийн хөрөнгө акталж, 1,661.6 мянган төгрөгийн хөрөнгийг Орон нутгийн өмчийн газрын шийдвэрийг үндэслэсэн байгууллагын даргын 2017 оны А/26 дугаар тушаалаар 3,515.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд шилжүүлж, 1,792,165.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд тайлант хугацаанд хөрөнгийн элэгдэл 6,887.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагджээ.

Тус байгууллагад 2017 онд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар аймгийн ОНХС-аас 59,412.6 мянга төгрөгийг төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр авч зарцуулсан байна.

1.12 Шилэн дансны мэдээлэл

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын "2 дугаар сургууль" Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бие даасан цэстэй бөгөөд 20 нэр төрлийн мэдээллийг 149 удаа оруулахаас 1 мэдээллийг хугацаа хоцроож, 99.2 % хэрэгжүүлсэн байна.

1.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Тус байгууллагын 2016 оны санхүүгийн тайланд Монгол Улсын Ерөнхий аудитор итгэл үзүүлж, "Зөрчилгүй" дүгнэлт өгсөн тул зөвлөмж өгөгдөөгүй байна.

1.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын "2 дугаар сургууль"-ийн 2017 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэлээ.

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын "2 дугаар сургууль"-ийн 2017 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж "Зөрчилгүй" санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл,

тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын "2 дугаар сургууль"-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 05 дугаар сарын 25-ны дотор Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг мэдэгдье.

**Асуудал 1: Анхан шатны баримтын
БҮРДЭЛИЙН ТАЛААР**

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №01

Илрүүлэлт

Зөвлөмж

Байгууллага, иргэнтэй байгуулсан
гэрээнүүд нь нэгдсэн журмаар

дугаарлагдаагүйгээс хянах боломжгүй бөгөөд гэрээг дүгнэж, акт үйлдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасныг зөрчсөн байна.

Байгууллага, иргэдтэй байгуулсан гэрээг урьдчилан дугаарлаж, гэрээний биелэлтийг дүгнэж байх

Хариуцах ажилтан

Дарга
Нягтлан бодогч

Л.Цэдэнсодном
Б.Анхтуяа

Эрсдэл

Нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байдал алдагдах.

Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн

Дарга
Нягтлан бодогч

Л.Цэдэнсодном
Б.Анхтуяа

Асуудал 1: Орлогын талаар

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №01

Илрүүлэлт

Биеийн тамир спортын зааланд явагдаж буй уралдаан тэмцээнээс зөвхөн УАШТ-ийг үзэгчдэд билет тасалж орлого бүрдүүлсэн байна. Харин жилдээ

Зөвлөмж

Төсвийн орлого бүрдүүлэх нөхцөл боломжийг судалж, идэвхи санаачлагатай ажиллах, бүсийн чанартай тэмцээн уралдааныг үнэ

бүсийн тэмцээн уралдаан 2-3 удаа төлбөртэй явуулж орлого бүрдүүлдэг явагддаг боловч үнэгүй төлбөргүй байх явуулж орлого олох боломжийг алдсан, орлого бүрдүүлэх талаар идэвх санаачлагатай ажиллаагүйгээс тайлант жилийн орлогын төлөвлөгөө 282.7 мянган төгрөг буюу 1.3 хувиар тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, 6.4.1, 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Хариуцах ажилтан

Дарга	Л.Цэдэнсодном
Нягтлан бодогч	Б.Анхтуяа

Эрсдэл

Нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байдал алдагдах.

Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн

Дарга	Л.Цэдэнсодном
Нягтлан бодогч	Б.Анхтуяа